$$E_{\mathrm{в}} = \frac{h_1 * E_1 + h_2 * E_2 + h_3 * E_3 * h_4 * E_4 * h_5 * E_5}{h_1 + h_2 + h_3 + h_4 + h_5} = \frac{6 * 1200 + 10 * 600 + 30 * 350 + 30 * 130}{6 + 10 + 30 + 30}$$

$$= \frac{27600}{76} = 363.16 \text{ МПа}$$

$$\frac{E_{\mathrm{в}}}{E_{\mathrm{н}}} = \frac{363.16}{108} = 3.36 \qquad \frac{\sum h}{D} = \frac{76}{37} = 2.05$$

Эдгээр харьцааг ашиглан [1]-н 16.9-р номограммаас τ –г олбол $\tau = 0.028$ МПа болж байна.

Хучилтын бүтээц дээр тооцооны ачаалал үйлчлэхэд үүсэх шилжүүлэх хүчдэлийг тодорхойлъё:

$$\mathrm{T} = \tau_{\mathrm{н}} * p = 0.028 * 0.6 = 0.0168\text{МПа}$$

Гулсалтанд шалгаж буй давхрагаас дээш орших хучилтын үеүүдийн дундаж хувийн жин:

$$\gamma_{\mathrm{ср}} = \frac{\sum(\gamma_i \times h_i)}{\sum h_i} = \frac{6 * 2400 + 10 * 600 + 30 * 350 + 30 * 130}{6 + 10 + 30 + 30} = \frac{25740}{76} = 338.68 \text{ МПа}$$

$$= 0.00033868\text{кг/см}^3$$

Элсэн шүүрүүлэх үе дээр шилжээсийн эсэргүүцлийн хязгаарын утгыг тодорхойлъё:

$$\mathrm{T}_{\mathrm{пр}} = \mathrm{K}_{\mathrm{д}} \times \mathrm{C}_n + 0.1 \times \gamma_{\mathrm{ср}} \times Z_{\mathrm{оп}} \times tan\varphi_{cm} = 1 * 0.045 + 0.1 * 0.00033868 * 76 * tan32 = 0.047 \text{ МПа}$$

Бат бэхийн нөхцлийг шалгая:

$$\frac{\mathrm{T_{пр}}}{\mathrm{T}} = \frac{0.047}{0.0168} = 2.797 > \mathrm{K_{пс}^{тр}} = 1$$

байгаа нь элсэнцэр үе дээрх хучилтын бүтээцийн шилжисхийлтийн эсрэг тогтворын нөхцөл биелэж байна.

Гулзайлтанд ажиллах цутгамал давхаргын суналтын эсэргүүцлийн тооцоо

Зөвшөөрөгдөх ачаалалын доорх гулзайлтанд ажиллаж буй хучилтын бүтээцийн бат бэхийг дараах нөхцөөр үнэлнэ.

$$\mathrm{K_{пр}^{тр}} \leq \frac{R_N}{\sigma_r}$$

R_N-Цутгамал давхарга гулзайлтанд ажиллах сунаснаас хучилтын бүтээцийн цуцалтыг тооцсон материалын бат бэхийн үзүүлэлт, мПа

Цутгамал давхарга нь гулзайлтанд ажиллахдаа олон дахин сунснаас бат бэх нь хэрхэн өөрчлөгдөхийг доорх томъёогоор тодорхойлно.

$$R_N = R_0 * k_1 * k_2(1 - v_R * t)$$

R_0-хаврын улирлын тооцооны бага температурт нэг удаагийн ачааллаар гулзайлтанд ороход үүсэх суналтын эсэргүүцлийн нормын утга-9.5 МПа /ГА-хав3, хүс1/

k_2-цаг уурын хүчин зүйлсийн нөлөөллөөр бат бэх буурахыг тооцсон коэффициент-0.9 /ГА-хүс6/

v_R-суналтан дахь бат бэхийн вариацын коэффициент-0.1 /ГА-хав4,хүс-1/

t- нормын хазайлтын коэффициент-1.71 /ГА-хав4, хүс2/

k_1-ачаалал үйлчлэхэд хучилт цуцсанаас бат бэх буурахыг тооцсон коэффициент

$$k_1 = \frac{\alpha}{\sqrt[m]{\sum N_p}} = \frac{6.3}{\sqrt[5]{979994}} = 0.40$$

α- лабораторын нөхцөл болон бодит байдал дохь давтагдах ачааллын үйлчлэлийн зөрүүг тооцсон коэффициент- 6.3 /ГА-хав3, хүс1/

m- тооцож буй цутгамал үеийн материалын шинж чанараас хамаарсан зэргийн үзүүлэлт-5

σ_r-Хучилтын бүтээцийг сунгах хүчдэл, МПа

$$\sigma_r = \overline{\sigma_r} * p * k_B$$

$\overline{\sigma_r}$-нэгж ачааллын үйлчлэлээр үүсэх сунгах хүчдэл

p-тооцооны ачааллаас ирэх дугуйн даралт-0.6 МПа

k_B-хучилгын хүчдэлт төлөв байдлын онцлогийг тооцсон коэффициент-0.85 /давхар дугуйтай үед/

Хучилтын цутгамал бүтээц гулзайлтанд ажиллахад хучилт сунаснаас үүсэх цуцалтанд бат бэхийг тооцоолъё. Хучилтын бүтээцийг хоёр үет системүү шилжүүлнэ.

Суурь үеэс дээш орших хучилтын бүтээцийн ерөнхий уян харимхайн модулийн дундаж утгыг тодорхойлъё.

$$\sum h_i = 6 + 10 = 16 \text{ см}$$

$$E_B = \frac{3600 * 6 + 600 * 10}{16} = 1725 \text{ МПа}$$

Тооцоот сунгах хүчдэлийн утгыг тодорхойлъё:

$\frac{E_B}{E_н} = \frac{1725}{290.03} = 5{,}95$; $\frac{\sum h}{D} = \frac{16}{37} = 0.43$ харьцаанаас хамаарч тодорхойлходг $\overline{\sigma_r} = 2.5$

Автомашины дугуйнаас ирэх ачааллын үйлчлэлээр хучилтын давхаргыг сунгах хүчдэлийг тодорхойлъё:

$\sigma_r = \overline{\sigma_r} * p * k_B = 1.9 * 0.6 * 0.85 = 0.969$ МПа

Асфалтбетон үеийн суналтын хүчдэлийн хязгаарын утгыг тодорхойлъё:

$R_N = R_0 * k_1 * k_2(1 - v_R * t) = 9.5 * 0.47 * 0.9(1 - 0.1 * 1.71) = 3.33$

Бат бэхийн нөхцөлийг шалгая:

$K_{пр}^{тр} = 1 \leq \frac{R_N}{\sigma_r} = \frac{3.33}{0.969} = 3.43$ байгаа тул суналтын эсэргүүцлийн нөхцөл биелэж байна.

6. УУЛЗВАР ОГТЛОЛЦОЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОГСООЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

6.1 УУЛЗВАР ОГТЛОЛЦОЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Төлөвлөж буй авто замд нийт 3 уулзварыг төлөвлөсөн болно. Огтлолцож буй авто замууд нь хүнд даацын тусгай зориулалтын авто замууд учир эргэлтийн хамгийн бага радиусыг 30м байхаар тооцлоо. Тооцоот тээврийн хэрэгслийн хамгийн бага эргэлтийн радиус нь 18.3м байдаг байна.

Хүснэгт 4-19. Төлөвлөж буй уулзвар огтлолцолууд

№	Байрлал	Огтлолцож буй автозам	Огтлолцож буй өнцөг
1	пк0+860.0м	Туслах зам-1	90°0'0.0"
2	пк2+260.0м	Туслах зам-2	116°46'16.0"
3	пк3+398.16м	Оюу толгой-Гашуун сухайтын авто зам	157°23'21.5"



Уулзвар 6-1. Гол зам болон Туслах зам-1-тэй холбогдох хэсгийн уулзвар огтлолцол



Уулзвар 6-2. **Гол зам болон Туслах зам-2-тэй холбогдох хэсгийн уулзвар огтлолцол**



Уулзвар 6-3. Гол зам болон Оюу толгой-Гашуун сухайтын хатуу хучилттай автозамд холбогдох хэсгийн уулзвар огтлолцол

6.2 ЗОГСООЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Төлөвлөж буй авто замын трассын Гол зам-1-н эхлэлд пк0+020.0м-ё пк0+058.0м-н хооронд 45м урт 17м өргөн нийт 30 авто машин зогсох багтаамжтай зогсоол төлөвлөлөө.

Зогсоолын хучилтын хийц нь гол зам-1-н хучилтын хийцтэй адилхан байна.



Зураг 6-4. Төлөвлөж буй авто зогсоол /пк0+020.0м-с пк0+058.0/

7. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ШИЙДЭЛ, ЗАМЫН ТОНОГЛОЛ ТӨЛӨВЛӨЛТ

7.1 ЗАМЫН ТЭМДЭГ

Зургийн даалгавар болон "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016-ийн шаардлагын дагуу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөн зохион байгуулалтыг ойлгомжтой болгох зорилгоор дохионы шон, замын тэмдэгүүдийг шаардлагатай газарт нь байрлуулахаар төлөвлөж өгөв. Замд тавих тэмдэгийг

- Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага - MNS 4597:2014
- MNS 4759:2014
- Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм - MNS 4596:2014-ийн дагуу хийж гүйцэтгэхээр зураг төсөлд тусгасан болно.Тухайн авто замд хөдөлгөөний аюулгүй байдал хангах хамгийн ашигтай боломжит арга зам нь замын тоноглол байрлуулах болно. Авто замын тоноглол нь зам ашиглалтын хэвийн нөхцөл, хөдөлгөөний аюулгүй байдал зэргийг хангахад чиглэгдсэн байдаг. Авто замын тоноглолуудад тэмдэг ба тэмдэглэл багтах ба энэ нь зорчигчидыг хоорондоо зохицох гол дүрэм болж өгдөг. Ингэснээр авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах боломж бүрдэнэ. Замын тэмдэглэгээ нь ямар ч нөхцөлд халхлагдаагүй үзэгдэх зай болон нөхцөл сайн хангагдсан байна.

Хүснэгт 7-1 Хэрэглэгдэх тэмдгийн ерөнхий хэмжээс

Тэмдгийн төрөл хэмжээ	Хэрэглэх тэмдгүүд	
	суурин газрын гадна	суурин газарт
I (жижиг)	Нэг эгнээтэй зам	Туслах чанарын зам
II (хэвийн)	**Хоёр буюу гурван эгнээтэй зам**	**Төв зам**
III (том)	4 буюу түүнээс олон эгнээтэй зам - Тууш зам	Хурдны зам буюу тууш зам
IV (хэт том)	Тууш зам дээрх засварын ажил; хэрэглэх нь үндэслэлтэй бол бусад зам дээрх аюултай хэсэг	

Хүснэгт 7-2. Анхааруулах тэмдэг



Тэмдгийн дугаар	Төрөл хэмжээ	A [мм]	г [мм]
1.18.а, 1.18.б 3.3.б, 3.3.в, 3.4	II	700	300

Хүснэгт 7-3. Дарааллын тэмдэг



Тэмдгийн дугаар	Төрөл хэмжээ	B [мм]	г [мм]
3.1	II	700	40

Хүснэгт 7-4. Мэдээлэх тэмдэг

	Тэмдгийн дугаар	Төрөл хэмжээ	B [мм]	r [мм]
	5.7, 5.17	II	700	40

Хүснэгт7-5. Хориглох тэмдэг

	Тэмдгийн дугаар	Төрөл хэмжээ	A [мм]	r [мм]
	2.1, 2.17, 2.20, 2.21, 2.24, 2.18.а б	II	600	40

7.2 ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

Хүснэгт 7-7. Тэмдэглэгээний төрлүүд

	1.1 Замын аюул бүхий хэсэгт эгнээний хилийг тэмдэглэх. Зорчих хэсгийн орохыг хориглосон хэсгийн хилийг тэмдэглэх
	1.5 Хоёр буюу гурван эгнээгээр зорчдог замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлах V≤60км/ц:L1=1.00-3.00, L2=3.00-9.00 L1 :L2 = 3:1
	1.6 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дагуу буюу эсрэг урсгалыг тусгаарласан 1.1, 1.10 тэмдэглэлд ойртож байгааг анхааруулах: V≤60км/ц : L1=3.0-6.0, L2=1.0-2.0

	1.11 "ЗОГС ШУГАМ" - гэрэл буюу зохицуулагчийн хориглосон дохио, эсвэл 3.5 "Зогсохгүй явах хориотой" тэмдгийн заалтыг биелүүлэхийн тулд тээврийн хэрэгсэл зогсох газрыг заах.

8. ХИЙМЭЛ БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨЛТ, УСЗҮЙН ТООЦОО

8.1 СУДАЛГАА ЯВУУЛСАН ҮНДЭСЛЭЛ

Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтын чинглэг тээврийн термоналаас Оюутолгой-гашуунсухайт чиглэлийн авто зам хүртлэх төлөвлөж буй авто замын зурвасын 14 цэгт ус өнгөрөөх барилга байгууламжууд (гүүр, хоолой)-аар өнгөрөх усны, ус зүйн судалгааг ажлын зургийн үе шатанд явууллаа.

Авто замын судалгаа явуулах гэрээг үндэслэл болгон замын зурвасын дагуух төлөвлөж буй ус өнгөрөөх барилга байгууламжийн ус зүйн сулалгааг 2024 оны 09-р сард хээрийн хайгуул судалгааг явуулж мөн оны 10-р сард суурин боловсруулалт, тооцооны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны аргачлал: Энэ хайгуул судалгаагаар замын зурвасыг хөндлөн гарч буй 14 цэгт том жижиг хуурай сайр, жалгын байршлыг М1:100000 бүхий байр зүйн зураг, Google eart агаарын зурагт буулгаж, ус хураах талбай, сайрын урт, уналт зэрэг сайруудын гидрографын үзүүлэлтүүдийг тодотгож, фото зургаар баримтжуулж, гар зураглал үйлдэв.

Хээрийн хайгуул судалгааны материалыг үндэслэн их үерийн урсацыг "Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм" (БНбД 2.01.14-86)-д заагдсан аргачлалыг үндэслэн $Q_{1\%}$, $Q_{2\%}$ $Q_{5\%}$ -ийн магадлалтайгаар тодорхойлж, ажлын зургийн үе шатны зураг төсөл зохиох ажлын түвшинд хийж гүйцэтгэв.

Дээрхи ажлыг хийж гүйцэтгэхийн тулд хоногийн хамгийн их хур тунадас, бусад үзүүлэлтүүдийг Даланзадгад, Ханбогд, Цогтцөций цаг уурын станцуудын олон жилийн ажиглалтын материал болон сав нутагт урьд нь хийгдсэн бусад /хөдөө аж ахуйн зориулалтаар/ хайгуул судалгааны материалуудыг авч ашиглалаа.

Замын зурвасын байрлал: Судалгаанд хамрагдаж буй замын зурвас хэсэг нь газар зүйн байрлалын хувьд Говийн их мужид, далайн түвшнээс дээш 1060-1180 м-ийн өндөрт, ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсацгүй голуудын ай савд, засаг захиргааны хувьд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт оршино.

Гадаргын хотгор гүдгэр: Судалгаанд хамрагдаж буй район ухаа гүвээт тал, талархаг гадаргатай, ихэнхи хэсэгт тархсан ухаа гүвээ, дов толгодууд нь харьцах өндрөөрөө хэдхэн арван метр байхаас гадна хажуу нь маш налуу, орой нь бөмбөгөр хэлбэртэй юм.

Ухаа гүвээт талын дунд энд тэнд дов толгод товойж харагдана. Эдгээр уул, толгодын хажуу нь шулуун төдийлөн эгц биш, орой нь хааяа шовх байдалтай байдаг. Судлагдсан раойнд хамгийн нам цэг нь 1065,1м, нийт өндрийн зөрөө 120 м байна. Эдгээр уулсаас эхтэй Их гүний сайр (27,8 км^2) бусад ус хураах талбай багатай зуны хур борооны нөлөөгөөр ихээхэн эрчимтэй үерлэдэг сайрууд төлөвлөгдөж буй авто замын зурвасыг хөндлөн гардаг.

Судалгааны район нь Ургамал-газар зүйн мужлалаар Евроазийн хээрийн их мужийн Төв Азийн дэд их муж Говийн умард цөлөрхөг хээрийн мужид хамаарагдана. Энэ бүс нутаг бол заримдаг сөөгөнцөр-бутлаг үетэнт ба таанат цөлийн хээрийн хаяа уулс, цав толгод, тал

газар, хотгорын говийн хэв шинжийн бор бударгана-хялганат бүлгийн ургамалжилт зонхилно.

Ургамалжилтын ерөнхий төрхийн хувьд нэг талаас цөлийн зарим элементүүд нэвтэрч байршсан байдаг учраас уулын хээр, цөлөрхөг хээрийн бүслүүр эзэлжлэн солигдоно. Цөлөрхөг хээрийн энэ нутгийн ургамалжилтын хувьд тачирхан, сийрэг, өдлөг хялганат, өдлөг хялгана-хазаарганат, өдлөг хялгана-таанат, өдлөг хялгана-боролзойт хээр зонхилоно.

Шавранцар-хайргархаг хотос хонхор хажуу, бэлээр баглуурт, бор бударганат цөл байхаас гадна хайргархаг-элсэнцэр хөрстэй газраар нь хойргот тост, модлог бударганат цөл зонхилно.

Уур амьсгалын нөлөөгөөр говийн хөрсний ургамалт үе нь нимгэн байдгаас гадна хуурай, элсэрхэг байх ба шим тэжээл маш ядмаг байдаг.

Тус муж говь, цөлийн бүсэд хамаарах тул говь-хээрийн ургамалшил зонхилож уулын бэлд ойн ургамалшил байхгүй.

8.2 УС ЗҮЙ, УУР АМЬСГАЛ

Судалгааны район нь Монгол орны нэгэн адил эрс тэс уур амьсгалтай, Төв Азийн гадагш урсацгүй голуудын ай савд багтах ба нийт нутагт гадаргын ус ховортой, тогтмол урсацтай гол горхи үгүй болно. Хамгийн том нь БНХАУ-ын нутгаас эх авсан Их гүний сайр (Хөх толгойн гол) (27,8 км^2) байна.

Замын зурвас нь зөвхөн зуны хур бороony үерийн үед урсацтай болдог хуурай сайр, жалгыг хөндлөн гарна.

Эдгээр сайрууд нь ус зүйн хувьд урьд өмнө судлагдаж байгаагүй болно.

Уур амьсгал: Судалгааны район нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд ерөнхийдөө өвөл нь удаан (хүйтэвтэр), зун нь аагим халуун (үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг), хур чийг харьцангуй бага, хавар, намар уулсын хөндий дагасан салхи их тохиолдох хуурай, дулаан бүсэд оршино. Уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Ханбогд. Цогтцэций харуулын олон жилийн ажиглалтын материалыг ашиглан агаарын температур, агаарын чийгшил, салхины горим гэсэн үзүүлэлтээр өгч хүснэгтээр харуулав.

Агаарын температур

Судалгааны район нь олон жилийн агаарын температур 4,4-7,3^{0}C байгаа нь дулаан бүсэд багтана. Агаарын температур хавар 3-р сарын сүүлчийн арав хоногт 0^{0}C-ийг давж дулаарч, хамгийн дулаан 7-р сард 35.0-38.0^{0}C дундажтай байх ба үнэмлэхүй их нь 39.5^{0}C байна. Намар 10-р сарын сүүлчийн арав хоногт 0^{0}C-ийг давж хүйтэрч, хамгийн хүйтэн 1-р сард –25.4^{0}C-ээс –28.3^{0}C дундажтай байх ба үнэмлэхүй бага нь -31.1^{0}C байна. Агаарт цочир хүйтрэлт ажиглагдах анхны хугацаа нь намар 10-р сарын дунд арав хоногт, эцсийн хугацаа нь хавар 5-р сарын сүүлчээр ажиглагдаж цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 100 орчим хоног байна.

Хөрсний температур

Бүс нутгаар хөрсний гадаргын температурын олон жилийн дундаж температур +8.8^{0}C-9,1^{0}C байх ба агаарын температурын жилийн явцтай нэгэн адил 1 дүгээр сард хамгийн хүйтэн (үнэмлэхүй бага температур -49.0^{0}C), 7 дугаар сард хамгийн дулаан (үнэмлэхүй их температур 61,4^{0}C) байна. Хөрсний гүнд цэвдэггүй бүсэд хамаарагдана.

Чийгшил ба тунадас

Энэ бүс нутагт газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч агаарын чийгшил нилээд дутмаг байдаг. Хүйтний улиралд агаарын харьцангуй чийгшил 45-60%, харин дулааны улиралд 35-45% байх ба жилийн явц нь өвөл, зун их утгаа авч хавар, намар хамгийн бага хэмжээтэй болдог. Ус бүс нутагт олон жилийн дундаж байдлаар 85.0-120.0мм тунадас унах ба түүний 80-90 орчим хувь нь зөвхөн дулааны улиралд буюу 7-9 дүгээр саруудад ордог байна. Анхны цас 10 дүгээр сарын сүүлчийн арав хоногт ажиглагдаж өвөл 1-5 см зузаан цасан бүрхүүл 110-150 хоног тогтож 4 дугаар сарын эхний арав хоногт сүүлчийн цас ажиглагдах ба 3 дугаар сарын дундаас хайлж эхэлдэг. Цасны нягт 0.18г/см^3 байдаг. Олон жилийн ажиглалтын материалаас үзэхэд хоногт орсон хамгийн их тунадас Даланзадгадад 1956оны 08-р сарын 05-нд 137.8мм, Ханбогдод 2003 оны 05-р сарын 06-нд 47,7мм тус тус ажиглагдсан байна.

Салхи

Тус районд баруун, баруун хойт ба баруун өмнөд зүгийн салхи зонхилох бөгөөд салхины хурд олон жилийн дунджаар 4.1м/с байх ба 100 жилд тохиолдож болох салхины хурд 42.0м/с байна.

Уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Ханбогд, Цогтцэций харуулын олон жилийн ажиглалтын материалыг болон “Барилгад хэрэглэх уур амьсгалын ба геофизикийн үзүүлэлтүүд” /БНбД 23-01-09/-ийг ашиглан харуулав.

Хүснэгт 8-1. Барилгад хэрэглэгдэх уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд

Уур амьсгалын үзүүлэлтүүд	Тоон утга
Агаарын жилийн дундаж температур	+6.9
Агаарын үнэмлэхүй их температур	+39.5
Агаарын үнэмлэхүй бага температур	-31.1
Хамгийн хүйтэн 5 хоногийн температур	-17.5
Хамгийн хүйтэн 1 хоногийн температур	-20.0
Хөрсний гадаргын дундаж температур	+8,8
Салхивчийн тооцооны температур	-12.7
Галлагааны хугацаа үргэлжлэх хоног	179 хоног
Эхлэх хугацаа	09 сар 15
Дуусах хугацаа	04 сар 11
Жилд буух хур тунадасны хэмжээ	85.1 мм
Дулаан улиралд буух хур тунадасны хэмжээ	79.9 мм
Тогтвортой цасан бүрхүүл тогтох дундаж хугацаа	12 сар 10
ханзрах дундаж хугацаа	03 сар 30
Хамгийн зузаан цасны дундаж	4.0 см
Цасны нягт	0.15г/см^3
Харьцангуй чийгшлийн жилийн дундаж	37 %
Салхины дундаж хурд	4.1 м/сек
Салхины тооцооны хурд 1 жилд	30 м/сек
5 жилд	33 м/сек
10 жилд	34 м/сек
20 жилд	38 м/сек

Цасан бүрхүүлийн зузаан

Манай орны газар нутгийн хотгор, гүдгэрийн ялгаанаас шалтгаалж цасны зузаан нь нутаг бүхэнд харилцан адилгүй байна. Цасан бүрхүүлийн зузааны горимыг цасны 10 хоногийн дундаж зузаан, цасны хамгийн их зузааны дундаж зэрэг үзүүлэлтээр илэрхийлдэг.

Цасны хээрийн хэмжилтээр гаргасан 10 хоногийн дунджаас үзвэл уулархаг хэсэгт (уулсын хоорондох хөндий) 5 см ба түүнээс дээш, хээрийн бүсэд 5 см хүртэл, говьд 1-2 см-ээс төдийлөн хэтэрдэггүй байна.

Авто замын уур амьсгалын нөхцөл

Авто зам төлөвлөж буй газар нь Монгол орны авто замын уур амьсгал, геотехникийн нөхцлийн ***IIIA, IIIB*** буюу говийн дэд бүсэд хамаардаг.

Энэ бүсийн онцлог нь Авто замын уур амьсгалын нэн хуурай дулаан, хүйтэн хүйтэвтэр хахирлаг говийн цөлжүү хээр, заримдаг газрууд юм. Мөн уур амьсгалын хүчтэй салхи шороон шуургатай, халуун бүгчим, хуурай онцлогтой. Энэ бүсийн зарим онцлог үзүүлэлтүүдийг доорхи байдлаар үзүүлэв.



Монгол орны авто замын уур амьсгалын бүсчилэл

Замын уур амьсгалын үзүүлэлтийг хавсралт хүснэгтэнд үзүүлэв

мянганы замын будуувч

Зохиогч уур амьсгал судлаач, газар зүйн ухааны доктор Г.Намхайжанцан
Авто замын зөвлөх МУ-ын зөвлөх инженер доктор У.Пүрэвжав
Хянан тохиолдуулсан Техникийн шинжлэх ухааны доктор, проф.Д.Дашжамц

Зураг 8-1. Монгол орны авто замын уур амьсгалын бүсчлэл

Хүснэгт 8-2. Бүсийн үндсэн тодорхойлолт

Бүсийн дугаар, нэр	дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Авто замын гео уур амьсгал, гео физикийн онцлог
1	*2*	*3*	*4*
III говь, цөлийн авто замын уур амьсгалын бүс	IIIA. говийн дэд бүс	-говийн цөлжүү хээр, заримдаг цөлийн авто замын уур амьсгалын нэн хуурай дулаан,хүйтэн хүйтэвтэр хахирлаг дэд бүс.	-Олон жилийн цэвдэггүй. Гео уур амьсгалын улирлын хөлдөлтийн гүн харьцангуй их 2.2-3.2м, хөөлттэй болон суулттай хөрсэлбэг тархсан авто замын уур амьсгалын хүчтэй салхи-шороон шуургатай, халуун бүгчим, хуурай онцлогтой. Газар хөдлөл 6-9 балл.
	IIIB. цөлийн дэд бүс	-говийн цөлжүү хээр, заримдаг цөлийн авто замын уур амьсгалын нэн хуурай дулаан-хүйтэн хүйтэвтэр цөлийн хахирлаг дэд бүс.	

Хүснэгт 8-3. Улирлын үргэлжлэх хугацаа

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	Эхлэх	Дууса х	Үргэлжл эх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжл эх хоног	Үргэлж лэх хоног
IIIA, B	2-15XI 9.XI	9-24.III 16.Y	126-46 136	25.IY-25.Y 1.Y	35-55 45	25.IX-1.X 28.IX	145-59 152	42-46 44

Тайлбар: * өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн эхлэл намрын дуусах хугацаа болно.

Хүснэгт 8-4. Хөрс, агаарын температурын (°C) үзүүлэлт

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчны дундаж температур		
	Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° нэвчих гүн, см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
IIIA,B	+3...+7	65-70	-39...-42	200-300	+2...+6	15...-20	20...25

Тайлбар: * -0^{0}C нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд, доод хязгаарыг авав.

Хүснэгт 8-5. Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
	Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
IIIA,B	1-10.XI 25.X	25.II-15.III 5.III	110-120 115	20.II-15.III 2.III	1-15.IV 7.IV	10-20 35

Хүснэгт 8-6. Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжгүй улирлын үеүүд

Дэд бүс	Дулааны улирал *			Хүйтний улирал
	Эхлэх	Дуусах	Хоног	Хоног
IIIA,B	20.III	25.X	228	137

Тайлбар: - Авто замын барилгын үйлдвэрлэлийн хүйтний улирлын эх нь дулааны улирлын төгсгөл, хүйтэн улирлын төгсгөл нь дулааны улирлын эх болдог

Хүснэгт 8-7. Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндрөөр	Харьцангуй чийгшил, %
	Өвөл	Хавар	Зун	Намар		
IIIA,B	2.5-4.0	3-6	2-5	2.5-4.5	650-700	40-60

Хүснэгт 8-8. Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл

Дэд бүс	Хүчилтөрөг-чийн нягт, г/см^3	Хувцас хунарын дулаан чанар, КЛО(хүндэвтэр ажлыг нөхцлөөр тооцов)			Уур амьсгал хүний биед, хоног		
		өвлийн	Хавар, намрын	Зуны	Таатай	Цочроох	Хурц

IIIA,B	250-225	4-4.5	2.5-3.0	1-1.3	180-195	120-135	20-30

Хүснэгт 8-9. Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд

Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр				
	Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	Чийгшлийн
IIIA,B	0.90	1.07	1.14	0.64	0.95

Хүснэгт 8-10. Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIIA,B	9.IY-2.V (20.IV)	5.IX-2.X (18.IX)	129-176 (151)

Хүснэгт 8-11. Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIIA,B	23.II-15.III (5.III)	12.IX-11.XII (27.XI)	244-301 (267)

8.3 УС ЗҮЙН СУДАЛГАА, ТООЦОО

Судалгаанд хамрагдаж буй замын зурвас хэсэг нь Төв Азийн гадагш урсацгүй голуудын ай савд орших бөгөөд байнгын урсацтай гол , горхи байхгүй зөвхөн зуны хур бороony үерийн үед урсацтай болдог хуурай сайруудыг хэндлэн гарна.



Зураг 8-2. Авто замын зурвас орчмын уул зүйн тойм зураг

Хээрийн судалгааны явцад замын зурвасыг байр зүйн зурагт буулгаж, сайр жалгын огтолж байгаа цэгүүдийг байршуулж, ус хураах талбайн ерөнхий байдал /ургамалшилт, хөрсний

бүтэц, ус хураах талбайн өргөн, сайрын урт болон гулдиролын тахиршилт, эргийн байдал зэрэг/-ын бичиглэл хийлээ.

Судалгаанд хамрагдаж байгаа замын зурвасыг дайран өнгөрөх сайруудын ус хураах талбайн гидрографийн үзүүлэлт /ус хураах талбайн хэмжээ, дундаж өндөр, хэвгий болон сайр жалгын урт, дундаж хэвгий зэрэг гидрографын үзүүлэлтүүдийг М1:100 000 масштаб бүхий байр зүйн зураг болон Google Eart Pro агаарын зураглал ашиглан тодорхойлж гаргав.

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт "Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм "/БНбД 2.01.14-86/ болон аман судалгаанаас үзэхэд зуны хур бороoны үер эрчимтэй явагдаж хаврын шар усны үер ажиглагдагүй тул хур бороoны үерийн хамгийн их урсацыг тооцоов. Хур бороoны үерийн их урсац нь хоногт хэдий хэмжээний хугацаанд, ямар эрчимшилттэй орсон бороoны байдлаас шалтгаалдаг тул хур бороoны үерийн их урсацын тооцоог гаргахын тулд хоногийн хамгийн их тунадасны хангамшлын тооцоог хийв.

ХОНОГИЙН ХАМГИЙН ИХ ТУНАДАС ТҮҮНИЙ ХАНГАМШИЛ: Хоногийн хамгийн их тунадасны статистик боловсруулалтыг хийхийн тулд сав газарт ойрхон бөгөөд эгнээ нь урт байгаа Даланзадгад, Ханбогд станцуудын цаг уурын ажиглалтын материалаас хоногийн хамгийн их тунадасыг авч ашиглан тооцож тодорхойлсон байдаг. Ажиглалтын эгнээнд моментийн аргаар статистик боловсруулалт хийж, хангамшлын муруй байгуулан 1%-ийн хангамшил бүхий хоногийн хамгийн их тунадасны хэмжээг тооцон гаргахад 81.9 мм, Ханбогдод 42.5 мм тус тус байсан байна.

Олон жилийн ажиглалтын материалаас үзэхэд хоногт орсон хамгийн их тунадас Даланзадгадад 1956 оны 08-р сарын 05-нд 137.8мм, Ханбогдод 2003 оны 07-р сарын 01-нд 47.7 мм тус тус ажиглагдсан байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уурын хүрээлэнгээс эмхэтгэн гаргасан " Монгол орны гадрагын ус" 1999 он номонд дурдсанаар хоногийн хамгийн их тунадасны 1%-ийн хангамж бүхий хэмжээг Даланзадгадад 113 мм, Ханбогдод 71,2 мм цаашдын тооцоонд H1%= 104 мм-ээр авч ашиглав.

ХАМГИЙН ИХ УРСАЦЫН ТООЦОО: Тухайн сав газрууд нь Монгол орны уруйн үер дунд зэрэг болж өнгөрдөг мужид хамаарагдах бөгөөд богино хугацаанд эрчимтэй орсон бороoны улмаас их хурдтай үер бууж ирдэг онцлогтой. Сүүлийн жилүүдэд ган гачиг болсоноор газрын гадарга, хөрсөн бүрхүүл дагтарчин хур бороо ойр зуурт эрчимтэй орж үер маш эрчимтэй ирдэг болж байна.

Төлөвлөж буй замыг хөндлөн гарах сайруудаас хамгийн том нь БНХАУ-ын нутагт тэрүүхэн орчимдоо өндөрлөг (1180 м) өндөрлөг толгодын дундаас эх авч урсаад элсэн хөрсөнд шургадаг Хөх толгойн гол юм. Хөх толгойн гол нь хур бороотой жил үерлэн Монгол орны нутагт Их гүний сайр нэрийг авч урсан ирж Гашуунсухайтын авто зам үерт автдаг байна. Бусад жижиг сайрууд нь Гашуунсухайт боомтын баруун талын Хөх хушууны толгодоос усжих жижиг сайрууд болно.

Хамгийн их үер 2018 оны 08 дугаар сард ажиглагдсан байдаг, Энэ үерээр Оюутолгой-Гашуунсухайт, Цогтцөций-Гашуунсухайтын авто замуудын ус өнгөрөөх байгууламжууд үерийн усыг өнгөрөөж чидахгүй зам усанд автаж ихээхэн хохирол учирсан байдаг

Зураг 8-3. Гашуунсухайтын боомт орчим 2018 оны 08 дугаар сард болсон үерээр автозам үерт автсан байдал

200 км^2-ээс бага ус хурах талбай бүхий гол горхи, сайруудын үерийн хамгийн их урсацын тооцоог (“Ус зүйн тодорхойлолтуудыг тооцох норм ба дүрэм” /БНбД 2.01.14-86./)-д заасны дагуу хур бороонь эрчимшилтийн аргыг ашигласан болно.

$$Q_{1\%} = q_{1\%} * \varphi\ H_{1\%} * \delta * p_{\%} * F$$

Энд: $Q_{1\%}$ - үерийн их урсац / м^3/с /

$q_{1\%}$ - үерийн их урсацын модуль / л/с км^2 /

φ - үерийн урсацын коэффициент

$H_{1\%}$ - 1% хангамжтай хоногийн хамгийн их тунадас / мм /

δ - нууршил, ой, намагшилтын коэффициент

$p_{\%}$ - 1%-ийн хангамшлаас шилжүүлэх коэффициент

F - ус хураах талбай / км^2 /

Урсацын хамгийн их урсацын модулийг ($q_{1\%}$-ийг) тодорхойлоход шаардагдах гулдрилын хэлбэр зүйн тодорхойлолт (Φ_r)-ийг дараах томъёогоор тодорхойлов.

$$\Phi_r=1000*L/ K_r*J_r*F^{1/4}*(\varphi*H)^{1/4}$$

Энд: Φ_r - голын хэлбэр зүйн тодорхойлолт

L - хөндлүүр хүртэлх гулдрилын урт /км/

K_r - гулдрил, татмын барзайлтын коэффициент

J_r - голын дундаж хэвгий

Ус цуглуулах талбайн хажуу бэлээр үер урсах хугацааг ($t_{хб}$) тодорхойлоход шаардагдах хажуу бэлийн хэлбэр зүйн тодорхойлолт ($\Phi_{хб}$)-ийг дараах томъёогоор тодорхойлов.

$$\Phi_{хб}= (1000*L_{хб})^{1/2} / n_{хб}*J_{хб}^{1/4}*(\varphi*H)^{1/2}$$

Энд: $\Phi_{хб}$ - хажуу бэлийн хэлбэр зүйн тодорхойлолт

$L_{хб}$ - ус хураах талбайн хажуу бэлийн дундаж урт /км/

$J_{хб}$ - хажуу бэлийн дундаж хэвгий

$n_{хб}$ - хажуу бэлийн барзайлтын коэффициент

Үерийн урсацын коэффициентийг дараах томъёогоор тодорхойлов.

$$\varphi=C_2*\varphi_0/(F+1)^{n6}*(Jc/50)^{n5}$$

Энд: C_2 - эмпирик коэффициент

(ойн бүсэд 1.3, бусад бүсэд1.2-оор авна)

φ_0 - F=10 км^2, Jc=50% байх үеийн урсацын коэффициент

n_5 - хөрсний бүтцээс хамаарах коэффициент

n_6 - уур амьсгалын бүсээс хамаарах коэффициент

(ойн бүсэд 0.07, бусад бүсэд 0.11-ээр авна)

САЙРУУДЫН ТОДОРХОЙЛОЛТ: Авто замыг хөндлөн гарах сайруудын үерийн урсацыг тооцох дүрс зүйн үндэс болох ус хурах талбай, сайрын урт болон хэвгий зэрэг үзүүлэлтүүдийг М1:100000 хураангуйлалтай байр зүйн зурагаас тодорхойлж нийтдээ 14 том жижиг сайрын тооцоо хийв.

Их гүний сайр 27,8 км^2 бөгөөд бусад сайр нь 0,1-1,0 км^2 хэмжээтэй жижиг сайрууд юм.

Замын зурвасыг дайран өнгөрөх сайруудын төрөл бүрийн хангамшилтай үерийн урсац, гидрографын үзүүлэлтүүдийг Хүснэгт -1 д үзүүлэв.

Хүснэгт 8-12. Автозамын гүүр, хоолойгоор өнгөрөх үерийн усны өнгөрөлт, гидрографын үзүүлэлтүүд

№	Гүүр-хоолойн дугаар	F (км2)	Lr (км)	Jr (‰)	Іхб (км)	q1% (л/сек. км2)	Q1% (м3/сек)	Q2% (м3/сек)	Q5% (м3/сек)
1	0+086.31	0.15	0.63	32.00	0.24	0.21	0.61	0.50	0.37
2	0+380.00	0.16	0.55	28.00	0.29	0.24	1.05	0.88	0.64
3	0+760.00	0.1	0.31	9.7	0.32	0.14	0.15	0.12	0.09
5	1+086.15	0.44	0.9	8.9	0.42	0.055	0.43	0.36	0.27
6	Их гүний сайр	27.8	11.9	9.6	2.34	0.03	17.35	14.40	10.58
8	1+903.41	0.95	1.68	20.9	0.52	0.079	0.82	0.68	0.50
9	2+060.00	0.27	1.08	27.8	0.25	0.21	1.05	0.87	0.64
10	2+387.29	0.29	1.49	24.8	0.19	0.13	0.67	0.56	0.41
11	2+703.20	0.2	0.75	30.7	0.27	0.27	1.09	0.91	0.67
12	3+021.83	0.3	1.57	25.1	0.19	0.13	0.70	0.58	0.42
13	3+158.40	0.67	2.1	29.5	0.32	0.1	1.31	1.09	0.80
14	3+271.73	0.1	0.65	38.5	0.15	0.3	0.67	0.56	0.41

Хүснэгт 8-13. Хоолойн нүхний тооцоо

№	Хоолойн байрлал, м	Талбай, км2	Жалгын урт, км	$Q_{1\%}$ (м3/сек)	Төлөвлөж буй хоолой
	Гол зам				
1	0+086.31	0.15	0.53	0.61	D=1.0м
2	0+380.00	0.16	0.54	1.05	D=1.0м
3	0+760.00	0.1	0.35	0.15	D=1.0м
4	1+086.15	0.44	1.24	0.43	D=1.0м
5	1+210.77	27.9	12.3	17.35	2.0x2.0x2хос
6	1+254.5				2.0x2.0x3хос
7	1+357.17				2.0x1.5x2хос
8	1+903.41	0.95	1.61	0.82	D=1.0м
9	2+060.00	0.27	1.08	1.05	D=1.0м
10	2+387.29	0.29	1.44	0.67	D=1.0м
11	2+703.20	0.18	0.73	1.09	D=1.0м
12	3+021.83	0.34	1.51	0.7	D=1.0м
13	3+158.4	0.65	1.83	1.31	D=1.0м
14	3+271.73	0.1	0.75	0.67	D=1.0м
15	3+371.62	Шуудуунд			D=1.0м
	Туслах-1				
16	0+061.25	0.1	0.39	0.61	D=1.0м
17	0+409.87	0.03	0.4	0.15	D=1.0м
	Туслах-2				
18	0+090.8	0.32	1.54	1.09	D=1.0м

Тайлбар бичиг боловсруулсан
"ХЗТ-Авто зам" ХХК-ны инженер Х.Ариунболд

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Ажлын даалгаврыг хавсаргана уу.]

Багц-1 Богинын тээврийн 3.9 км авто зам автозамын зураг төсөл боловсруулах, Ус зүйн судалгаа хийх ажлын даалгавар.

БАТЛАВ.
"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.БҮДБААР

ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ТЕРМИНАЛААС ГАШУУНСУХАЙТ БООМТ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 26-ны өдөр Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/22 дугаар тогтоол; Монгол Улсын Зам Тээврийн Хөгжлийн Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаар Гашуунсухайт орчимд байгуулах ачаны терминалын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар; "Тавантолгой төмөр зам" ХХК, 2022 он, Гашуунсухайт шилжүүлэн ачих терминалын техник эдийн засгийн үндэслэл; "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө;
2. Байршил	Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт
3. Замын техникийн ангилал, замын зэрэг	Хүнд даацын тээврийн хэрэгслийн тусгай зориулалтын авто зам (Байнгын хөдөлгөөнтэй, хөдөлгөөний 2 зурвастай, зорчих хэсэг нь зааглагдаагүй, тооцоот хурд нь 50 км/цаг)
4. Ажлын цар хүрээ	-Шилжүүлэн ачих терминалаас Гашуунсухайт боомт чиглэлийн 4.2 км орчим асфальт бетон хучилттай хүнд даацын авто зам
5. Замын хучилтын хийц	Асфальтбетон хучлагатай авто зам болон сайжруулсан шороон замын Хучилтын хийцийг тооцоогоор үндэслэнэ. Хөдөлгөөний ачуулгүй байдал, ашиглалтын техникийн нөхцлийг хангаж автомашин, явган хүний хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх боломжийг хангах
6. Төлөвлөлтийн норм	• "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 • "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02 • "Авто зам төсөллөх" БНбД 32-01-16 • "Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт" БНбД 30-01-04 • "Хот суурины гудамж зам төлөвлөлт" БНбД 32-01-04 • "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН 2.01.01-2004 • "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНбД 22-01-21 • "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНбД 3.01.03-88 • "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS4597:2014 • "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм"

	MNS4596:2014 • Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598: 2011 • Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНбД 32-02-12 • Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНбД 30-01-04 • "Барилгын инженер- геологи, геотехникийн судалгааны ажил" /БНбД 11-03-21/ • Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм БНбД 2.01.14-86
7. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	Нэг үе шаттай, 2024 оны 2 дугаар улиралд багтаан магадлуулах ажлыг гүйцэтгэнэ.
8 Зураг төслийн иж бүрдэл	• "Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНбД 3.01.03-98-д тавигдах шаардлагын дагуу байр зүйн хэмжилтийн ажлын тайлан • Буурь хөрс болон зам барилгын ажилд хэрэглэх түгээмэл тархацтай (чулуу, далан, суурийн хайрга, хөрс гэх мэт) материалын судалгааг багтаасан Инженер-геологийн хайгуул судалгааны ажлын тайлан • Ус зүйн иж бүрэн тооцоо судалгаа, авто замын ус зайлуулах байгууламжийн тооцоо • Дараах хэсгүүдийг нэгтгэсэн Авто замын ажлын иж бүрэн зураг төсөл: - Авто зам, хиймэл байгууламжийн ажлын иж бүрэн нарийвчилсан зураг төсөл; - Зам, замын байгууламжийн барилгын ажлын техникийн шаардлага, төсөв; - Зам, замын байгууламжийн барилгын ажлын төсөв; - Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ажлын нэр, холбогдох захирамж, гэх мэт) - Зам, гүүрийн зурваст орсон инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, засварлах, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардал; - Ажилбар тус бүрийн болон Барилгын ажлын нэгдсэн тоо хэмжээ; - Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ); - Зам барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд; - Шаардлагатай нөхцөлд тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн зураг төсөл; - Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг батлагаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт - Авто замын гэрэлтүүлгийн төлөвлөлт хийж ажлын зураг боловсруулах
9. Зураг төслийн байгууллага	Захиалагч "Тавантолгой төмөр зам" ХХК сонгон шалгаруулж гэрээ байгуулна
10. Захиалагч байгууллага	"Тавантолгой төмөр зам" ХХК

11. Онцгой нөхцөл	• Төлөвлөж буй авто замын трассыг хувилбаруудын харьцуулалтаар сонгон тогтоож, захиалагчтай зөвшилцөж санал авах, Захиалагчид танилцуулах; • Уулзвар гарцыг төсөллөхдөө хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг сайтар харгалзах; • Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагуух тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд төсөллөх; • Терминал дотор барилга байгууламжуудыг замтай холбосон холбоос зам, зогсоолын талбайг төсөллөх; • Ухмал ба зам дээр цас хуңгарлахаас сэргийлэх далангийн шийдлийг төсөллөх; • Халиа тошин, үер, уруйгаас хамгаалах байгууламжийг төсөллөх; • Гадаргуугийн ус зайлуулахдаа ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж шаардлагатай тохиолдолд давуулах далан төлөвлөх; • Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох; • Авто замын чиглэлийг тооцохдоо одоо ашиглаж байгаа шороон замыг голчлон ашиглах бөгөөд зарим хэсэгт тухайн замыг шуудуутгах зарчмыг баримтлах; • Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөлд тусгах; • Авто замын төлөвлөлтийг оргилцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлт, бусад инженерийн байгууламжуудтай сайтар уялдуулах; • Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг сайтар шийдвэрлэх; • Авто зам болон гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, чанарын шаардлага хангасан байдлаар шийдвэрлэх; • Тухайн авто замын үндсэн элементүүдийг (авто зам, хоолой, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглэгээ, инженерийн шугам сүлжээ ус зайлуулах байгууламж гэх мэт) Layer тус бүрээр салгаж Dwg файлаар өгөх; • Авто зам, замын байгууламжийн ажлын иж бүрэн зураг, төсөв, тайлбар бичиг, инженер-геологийн дүгнэлт, геодезийн тайлан, гадаргын усны урсцын тооцооны тайлан, техникийн шаардлага бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар 2 ш (хуулбар өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр / DWG болон PDF/ хүлээлгэж өгөх; • "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам" мөрдлөг болгон магадлалд оруулах; • Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд: - Дэвсгэр зураг 1:500 - Дагуу огтлол - хэвтээ 1:1000 - Босоо 1:100 - Хөндлөн огтлол 1:100 - Уулзвар, огтлолцол 1:500 - Бүтээц 1:20

	• Замын сүлжээг бүрдүүлэх үндсэн элементүүд болох зорчих хэсэг, хөдөлгөөн тусгаарлах зурвас, газар доорх инженерийн байгууламжийн оргилолцол, гадаргуугийн усыг зайлуулж, дамжуулах байгууламж зэргийг хамруулан иж бүрнээр төлөвлөнө.

Багц-2 Зам талбайн хайгуул, хэмжилт, зураг төсөл боловсруулах ажлын даалгавар.

БАТЛАВ
"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Ч.ГАРТААМ

ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ТЕРМИНАЛ ДОТОРХ АВТО ЗАМ, ЗОГСООЛЫН ТАЛБАЙ БОЛОН ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙН ХАТУУ ХУЧИЛТЫН НАРИЙВЧИЛСАН
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны ..... сарын .....-ны өдөр Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/22 дугаар тогтоол; Монгол Улсын Зам Тээврийн Хөгжлийн Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаар Гашуунсухайт орчимд байгуулах ачааны терминалын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар; "Тавантолгой төмөр зам" ХХК, 2022 он, Гашуунсухайт шилжүүлэн ачих терминалын техник эдийн засгийн үндэслэл; "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө;
2. Байршил	Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт, Гашуунсухайт шилжүүлэн ачих терминал
3. Авто зам, талбайн техникийн ангилал, замын зэрэг	Хүнд даацын тээврийн хэрэгслийн тусгай зориулалтын асфальтбетон хучилттай авто зам
4. Шилжүүлэн ачих терминал болон зогсоол хоорондын авто зам, ачаатай болон ачаагүй чингэлэг тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн хучилтын хийц	• Авто замын хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ. • Ачаатай болон ачаагүй чингэлэг тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн хучилтыг тооцоогоор үндэслэнэ.
5. Төлөвлөлтийн норм	• "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 • "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02 • "Авто зам төсөллөх" БНбД 32-01-16 • "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН 2.01.01-2004 • "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНбД 22-01-21 • "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНбД 3.01.03-88 • "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS4597:2014 • "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS4596:2014 • Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598: 2011 • Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНбД 32-02-12

	• "Барилгын инженер- геологи, геотехникийн судалгааны ажил" /БНбД 11-03-21/ • Авто зогсоол ангилал ба өрөнхий шаардлага MNS 5342:2007 • БНбД 11-07-04 инженер геодезийн ажил • БНбД 3.01.03.88 Геодезийн ажил • "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНбД 81-013-2019
6. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	Нэг үе шаттай, 2024 оны 2 дугаар улиралд багтаан магадлуулах ажлыг гүйцэтгэнэ.
7. Зураг төслийн иж бүрдэл	• Инженер, геодезийн ажлын тайлан • Инженер геологийн судалгааны ажлын тайлан • Авто зам, замын байгууламж, зогсоолын талбайн инженерийн нарийвчилсан ажлын зураг • Тайлбар бичиг /хучилтын тооцоо, ус зүйн тооцоо, тухайн бүс нутгийн байгаль, цаг уурын статистик мэдээ, төслийн шийдэлд онцгой нөлөө үзүүлэх байгаль цаг уурын хүчин зүйлсийн тухай мэдээ, ажлын нэр, тоо хэмжээ, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт/ • Техникийн шаардлага • Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв
8. Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагыг Захиалагч "Тавантолгой төмөр зам" ХХК сонгон шалгаруулж гэрээ байгуулна
9. Захиалагч байгууллага	"Тавантолгой төмөр зам" ХХК
10. Онцгой нөхцөл	• Хучилтын бүтээцийг тухайн чиглэлийн замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, хэтийн өсөлт, тэнхлэгийн ачаалал, овор хэмжээ зэргийг нарийвчлан тооцож төсөллөх; • Терминал дотор барилга байгууламжуудыг замтай холбосон холбоос зам, зогсоолын талбайг төсөллөх; • Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох; • Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөлд тусгах; • Байр зүйн болон өндрийн хэмжилтийг WGS84 систем, UTM48 тусгагт хийх; • Зогсоолын талбайд тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн жолооч бусдын хөдөлгөөнд саад учруулахааргүй зорчих зурвасын тэмдэг тэмдэглэгээг зураг тодорхой тусгах; • Авто зам болон зогсоолын талбайн гадаргуун усыг зайлуулах байгууламжийг төсөллөх; • Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохион байгуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах; • "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам" мөрдлөг болгон магадлалд оруулах; • Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

	- Дэвсгэр зураг 1:500 - Дагуу огтлол - хэвтээ 1:1000 - Босоо 1:100 - Хөндлөн огтлол 1:100 • Замын сүлжээг бүрдүүлэх үндсэн элементүүд болох зорчих хэсэг, хөдөлгөөн тусгаарлах зурвас, газар доорх инженерийн байгууламжийн огтлолцол, гадаргуугийн усыг зайлуулж, дамжуулах байгууламж зэргийг хамруулан иж бүрнээр төлөвлөнө; • Авто зам, замын байгууламжийн ажлын иж бүрэн зураг, тесөв, тайлбар бичиг, геодезийн тайлан, техникийн шаардлага бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар 2 ш (хуулбар өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр / DWG болон PDF/ хүлээлгэж өгөх;

Хянасан:

Зураг төсөл, технологийн хэлтсийн дарга Э.Чанцалдулам

Боловсруулсан:

Замын ахлах инженер М.Бат-Эрдэнэ

Зургийн инженер Н.Билгүүн

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 1,
Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн тев байр.
Утас: (976)-70112519, Факс: (976-11)-325445
И-мэйл: info@icn.mn, http://www.icn.mn

2024.11.04 № 03/910

танай _____-ны № _____-т

ХЗТ-АВТОЗАМ ХХК-Д

Хариу хүргүүлэх тухай

Танай компаниас ирүүлсэн 24/224 тоот албан бичиг, ажлын зурагтай танилцан Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн шилэн кабель, шинээр хийгдэх авто замын хэсэгт орсон эсэхийг хянаж, тодруулга хийсэн

Өмнөговь аймаг, Ханбогд сум, Хайрхан баг, Гашуунсухайт хилийн боомтод шинээр хийгдэж байгаа 3,9 километр авто замын ажлын хэсэгт манай компанийн шилэн кабель ороогүй болно.

Зураг зааснаас бусад хэсэгт газар шорооны ажил хийх бол манай компанитай зөвшилцөн техникийн нөхцөл авч хамтран ажиллана уу.

ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА,
ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ А.ГАНТУЛГА

152401217

МОБИКОМ
НЭТВОРКС ХХК

14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Юнескогийн гудамж - 28, МҮМ Цогцолбор, Утас: 75759944,
Факс: +976-11-310411, http://www.mobicom.mn

2024.10.25 № 24/305

танай 2024.10.22 -ны № 24/226 -т

ХЗТ-АВТОЗАМ ХХК-Д

Танай компаниас ирүүлсэн албан бичгийн дагуу шалгаж үзэхэд Гашуун сухайт боомт чиглэлийн шилэн кабелийн трасстай доорх цэгүүдэд давхцал үүсэж байна. Үүнд:

1. 42.438509°, 107.549263° - Мобиком Нэтворкс ХХК
2. 42.439724°, 107.548820° - Мобиком Нэтворкс ХХК
3. 42.442103°, 107.545886° - Мобинет ХХК

Иймд давхцал үүссэн хэсгүүдийг зураг төлөвлөн ажлын төсөвт тусгаж өгнө үү.

ТЕХНИКИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ Б.ГАНЗОРИГ

mobicom networks
УЛААНБААТАР ХОТ
МОБИКОМ НЭТВОРКС ХХК

000702

INTEGRATED MANAGEMENT SYSTEM

DIIP хөгжлийн хөтөч

"ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ-ДЭД БҮТЭЦ" ТӨСӨЛ

Монгол Улс, Улаанбаатар Чингэлтэй дүүрэг,
5-р хороо Ж.Самбуугийн гудамж Эм Эн Тауэр, 15 давхар
1807 тоот, Утас: 70002555, E-mail: info@diip.mn

2024. 10. 23 № 419

танай ____ -ны № ____ -т

"ХЗТ-АВТО ЗАМ" ХХК

Хариу хүргүүлэх тухай

Танай компанийн төлөвлөж буй Богинын тээврийн 3.9км авто замд манай төслийн хүрээнд хэрэгжсэн хилийн Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтай холбоотой шийдвэрлэх шаардлагатай дараах асуудлууд үүсэж байна. Үүнд:

1. Танай төлөвлөж буй авто зам нь Хайрхан багаас Гашуунсухайт боомт хүртэлх тус боомтын төвийн ус хангамжийн гадна шугамтай давхцаж байгаа ба уг хэсэгт хамгаалалт төлөвлөх,
2. Боомтын орох хэсэгт байрлах ус зайлуулах хоолойн гарах хэсгийг хааж шороон далан барьсныг нурааж усны урсгалыг залах ажлыг ажлын тоо хэмжээнд нэмж оруулах,
3. Боомтын арын үерийн хамгаалах байгууламж дээгүүр тээвэрлэлт хийгдэж байгаа ба тус замыг ашиглалтаас гарах үед ус зайлуулах шуудууг нөхөн сэргээх, засварлах ажлыг ажлын тоо хэмжээнд оруулж зураг төслөө боловсруулна уу.

Хувийг: "Тавантолгой төмөр зам" ХХК-д.

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Ж.ГАНБААТАР

МОНГОЛ УЛС ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ДЭД БҮТЭЦ ТӨСӨЛ

05865

БАТЛАВ.
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР
НУТГИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Н.БААТАРЦОГТ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ
ГАЗАР АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 04 дүгээр
сарын 07-ны өдөр Дугаар 24/32 Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 310 дугаар тогтоолыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын яам (цаашид "газар ашиглуулагч" гэх), "Тавантолгой төмөр зам" ХХК (цаашид "газар ашиглагч" гэх) харилцан тохиролцож, дор дурдсан нөхцөлөөр энэхүү гэрээг 5 жилийн хугацаатай байгуулав.

1.2. Гэрээний зорилго нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Говийн Бага Дархан цаазат газарт байрлах "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн ашиглаж буй барилга байгууламж, шилжүүлэн ачих терминал, инженерийн дэд бүтцийг барих, ашиглах, суурьшлын бүс байгуулах, "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр зам барих зорилгоор газар ашиглах, ашиглуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.3. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний үндсэн хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

1.3.1. Газрын байршил, талбайн хэмжээ, хил заагийг тодорхойлсон кадастрын зураг;

1.3.2. Төслийн бүтээн байгуулалтын техник-эдийн засгийн үндэслэл;

1.3.3. Археологи, палеонтологи, түүх угсаатны авран хамгаалах судалгааны ажлын тайлан.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрх, үүрэг

2.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журмыг тогтооно.

2.1.2. Харьяа байгууллага болох Говийн бага дархан цаазат газрын Хамгаалалтын захиргаагаар төлөөлүүлэн газрыг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх, газрын төлөв байдал, чанарт хяналт тавина.

2.1.3. Газар ашиглагчаас тухайн газартай холбоотой шаардлагатай баримт бичгийг гаргуулан авна.

2.1.4. Ашиглуулахаар олгосон газрын байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчныг хамгаалах тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг батална.

2.1.5. Газар ашиглахтай холбоотой тушаал шийдвэр, холбогдох стандарт, нормын хэрэгжилтэд хяналт тавих, газар ашиглагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлнэ.

2.1.6. Төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих.

2.1.7. Энэ гэрээний дагуу ашиглаж буй газрыг мэдээллийн нэгдсэн санд бүртгэн, ашиглаж буй газартай давхцуулан газар ашиглуулах гэрээ байгуулахыг хориглоно.

2.1.8. Хуульд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.2. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн эрх, үүрэг

2.2.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, горимыг мөрдөх, зөвхөн тогтоосон газарт гэрээнд заасан зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулна.

2.2.2. Газар ашиглагч нь төсөл хэрэгжүүлэхдээ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг газар ашиглуулагчаар батлуулж хэрэгжилтийг хангана.

2.2.3. Төслийн бүтээн байгуулалтад ойн сан бүхий газар хөндөгдөх тохиолдолд экологи эдийн засгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, модлог ургамлыг шилжүүлэн суулгах арга хэмжээг авах, нөхөн сэргээхэд анхааран ажиллана.

2.2.4. Ашиглаж байгаа газартаа хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

2.2.5. Газар ашиглуулагчаас болон төрийн байгууллагуудаас гаргасан захиргааны актын хэрэгжилтийг хангаж, дагаж мөрдөнө.

2.2.6. "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тавигдсан шаардлагыг бүрэн биелүүлж, тайланг заасан хугацаанд хамгаалалтын захиргаа болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.2.7. Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.4-д заасны дагуу газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2.2.8. Газрыг ашиглахдаа байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авч ажиллана.

2.2.9. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

ГУРАВ. УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ ДАХЬ ХАМГААЛЛЫН ДЭГЛЭМ

3.1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон тэдгээрийг дагалдан гарсан хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллахаас гадна дараах тусгай дэглэмийг мөрдөнө. Үүнд:

3.1.1. Стандартын бус ариун цэврийн байгууламж барьж, хөрс, ус бохирдуулах, зөвшөөрөгдсөн талбайн хэмжээнээс хэтрүүлэн газар ашиглах, зөвшөөрөлгүй худаг гаргах, шинээр олон салаа шороон зам гаргах, зэрлэг амьтан тэжээх, харь зүйлийн мод, бут, ургамал үрслүүлэх, тарих, ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад дамжуулан ашиглуулахыг тус тус хориглоно.

3.1.2. Тоосжилт дарах болон хортон шавж, түймэр зэрэг эрсдэлээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй техник хэрэгсэл сонгох, химийн хортой бодис ашиглахыг хориглоно.

3.1.3. Төслийн явцад тухайн газрын экосистемийн (хөрс, ус, ургамал амьтан зэрэг) байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдэд учруулсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд экологи эдийн засгийн үнэлгээгээр тооцож хохирлыг барагдуулна.

3.1.4. Тухайн газарт зөвшөөрөгдсөнөөс бусад төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно;

3.1.5. Улсын хилийн халдашгүй дархан байдал, улсын хил хамгаалалтын эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй байх;

3.1.6. Хөрс, орчны бохирдлыг хянах, мэдээлэх, урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах.

ДӨРӨВ. БУСАД

4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталсан өдрөөс эхлэн хуанлийн 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.2. Талуудын аль нэг гэрээг дуусгавар болгох санал гаргаагүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

4.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба энэ хэсэгт тоочсон нөхцөл үүссэн тохиолдолд гэрээг сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл гэрээг шинэчлэн байгуулж болно. Уг шинэчилсэн гэрээ энэхүү гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:

4.3.1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр төсөл хэрэгжих газрын буюу тусгай хэрэгцээний газрын ангилал өөрчлөгдөх;

4.3.2. Ашиглаж буй газрын хэмжээнд өөрчлөлт орох;

4.4. Гэрээг 3 хувь үйлдэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар, Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, "Тавантолгой төмөр зам" ХХК-д тус бүр нэг хувийг хадгална.

4.4. Талууд энэхүү гэрээтэй холбоотой үүссэн маргааныг харилцан ойлголцож, эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГОВИЙН БАГА
ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА

Ч.БАТСҮХ

40010 Өмнөговь аймаг, Ханбогд сум
И-мэйл: smallgobi@mpa.gov.mn
Вэбсайт: www.smallgobi.mpa.gov.mn
Утас: 88030903

"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.БУДБАЯР

14230 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Нарны зам 62, Юнион Бюлдинг, 11 давхар
Утас: 7777 7727, 7777 7877
И-мэйл: info@ttz.mn Вэбсайт: www.ttz.mn